МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр Дугаар А/123 Мөрөн сум

Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны даргын ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Р.Машбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, Эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: Г.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Отгончимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Өнөржаргал (Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны Архив бичиг хэрэг, хариуцсан ажилтан)

Нарийн бичгийн дарга:

Ц.Баасанжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2.Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын даргын ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, төслийг Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлд хянуулахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Машбат)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024
6710010369